ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ГЭР БҮЛ, ХӨҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 14 өдөр Дугаар А/27 Сүмбэр сум

Гэр бүлийн хөгжлийг дэмжих сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хүүхэд хамгаалллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.6 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн зорилтот өрхийн гишүүдийг амьдрах ухааны чадварт сургах, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэл тус бүрийн сургалтыг зохион байгуулах ажлын удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Дээрх үйл ажиллагааг зохион байгуулж үр дүнг тайлагнаж ажиллахыг Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Ч.Анхтуяа)-д үүрэг болгосугай.

3.Дээрх үйл ажиллагаанд зарцуулагдах 360.000 (гурван зуун жаран мянга) төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг нягтлан бодогч (Д. Оюунцэцэг)-д зөвшөөрсүгэй

ДАРГА Ц.ОЮУНБИЛЭГ

D:/Бичиг хэрэг /тушаал

166

ГБХЗХГазрын даргын 2021 оны
04 сарын 14-ний өдрийн 01/127
дугаар тушаалын 1-р хавсралт

9018379
ATA3412 3219110003

ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

2021.04.13. Говьсүмбэр аймаг

Нэг. Үндэслэл

МУ-ын төрөөс гэр бүлийн талаар баримтлах бодлого, МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 01/191 дугаар чиглэлийн хэрэгжилтийг хангах орон нутгийн зорилтот гэр бүлүүдэд гэр бүлийн боловсрол, хууль эрх зүйн талаар мэдлэг олгох сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулахад оршино.

Тус аймгийн 2020 оны статистикийн мэдээгээр нийт хүн ам 18008, өрхийн тоо 5061 байна. Үүнээс өрх толгойлсон эмэгтэй 648, өрх толгойлсон эрэгтэй 120 байна. 2020 онд гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн хэрэг 29, гэмт хэрэг 4 шалгагдан шийдвэрлэгдсэн байна. 2019 онд шинээр гэр бүл болсон 73, салсан 23, 2020 онд шинээр гэр бүл болсон 44, салалт 18 бүртгэгдсэн байна. Энэ нь нийт гэр бүл болохоор батлуулсан гэр бүлийн 2019 онд 31,5%, 2020 онд 78,2% салсан үзүүлэлт гарсан байна.

Хоёр. Зорилго

Аймгийн зорилтот өрхийн гишүүдэд гэр бүлийн харилцаа, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын талаар мэдлэг ойлголтыг өгч, гэр бүлийн тогтвортой байдлыг ханган хөгжүүлэх чиглэлээр үе шаттай сургалтыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах.

Гурав. Зохион байгуулагч

Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар.

Дөрөв. Сургалтыг чиглүүлэгч багш нар

ГБХЗХГ-ын Гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ч. Анхтуяа, Залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Урангоо, Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн Э.Урантунгалаг, Сэтгэл зүйч Г.Мөнхчимэг

Тав. Хугацаа, Хаана

2021 оны 04 сарын 19, 20, 21, 23, 27, 28-ны өдрүүдэд онлайнаар зохион байгуулагдана.

Зургаа. Хамрах хүрээ

D:/Бичиг хэрэг /тушаал

Аймгийн хэмжээнд бүртгэлтэй эрсдэлийн түвшин өндөр зорилтот бүлгийн нийт 120 гэр бүлийн эцэг, эх, хүүхдүүд хамрагдана.

Долоо. Сургалтын зохион байгуулалт

	Сургалтын сэдэв	Хугацаа	Чиглүүлэгч
	ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД		
	Бүртгэл	09^{30} -10^{00}	Гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ч.Анхтуяа
1	Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн орчин дахь хүүхэд хамгаалалд эцэг эхийн үүрэг, хариуцлага	10^{00} -10^{40}	Гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ч.Анхтуяа
2	Гэр бүлийн харилцаа	10^{40} -11^{20}	Гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ч.Анхтуяа
3	Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга	11^{20} -12^{00}	Залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Урангоо
4	Өрхийн төсвөө хэрхэн төлөвлөх вэ	12^{00} -12^{40}	Залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Урангоо
	Завсарлага	12^{40} -14^{00}	
5	Стресс ба түүнийг даван туулах арга зам	14^{00} -14^{40}	Сэтгэл зүйч Г.Мөнхчимэг
6	Архидалт ба түүний хор хөнөөл	14^{40} -15^{20}	Сэтгэл зүйч Г.Мөнхчимэг
7	Гэр бүлийн үнэ цэнэ	15^{20} -16^{00}	Гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ч.Анхтуяа
	ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТ		
	Бүртгэл	13^{40} -14^{00}	Гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ч.Анхтуяа
1	Хүүхдийн эрхийн тухай хууль. Хүүхдийн эрх, хүүхдийн журамт үүрэг / 8-18 насны хүүхдүүдэд/	14^{00} -14^{30}	Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн Э.Урантунгалаг
2	Үе тэнгийн гадуурхалт /10-18 насны хүүхдүүдэд/	14^{30} -15^{30}	Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн Э.Урантунгалаг
3	Харилцаа ба түүнд баримтлах зарчим	15^{30} -16^{00}	
4	Нөхөн үржихүйн эрүүл мэнд /13-18 насны хүүхдүүдэд/	16^{00} -16^{30}	Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн Э.Урантунгалаг

Найм. Үр дүн

Эцэг эхчүүдэд

- ✓ Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, гэр бүлийн орчинд хүүхэд хамгаалалд эцэг эхийн үүрэг оролцооны талаар ойлголттой болсон байна.
- ✓ Хүүхэд хүмүүжүүлэх эрэг аргын талаар мэдлэг ойлголттой болсон байна.
- ✓ Гэр бүлийн бодит байдал, орчин нөхцөлийн талаарх үзэл бодол, ойлголт нь улам тэлэгдсэн байна.
- ✓ Гэр бүлийн харилцаанд гардаг сөрөг зан үйл, хандлагын талаар ойлголттой болж түүнийг даван туулах арга зүйд суралцсан байна.
- ✓ Өрхийн төсөв ба түүнийг хэрхэн зөв зохион байгуулах талаар ойлголттой болж өрхийн төсвөө хөтлөх арга зүйг эзэмшсэн байна.

Хүүхдүүдэд

- ✓ Хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхдийн эрх, үүргийн талаар ойлголттой болсон байна.
- ✓ Үе тэнгийн дээрэлхэлт, цахим гадуурхалт түүнийг даван туулах арга замын талаар ойлголттой болсон байна.
- ✓ Хүүхдүүд өсвөр нас, шилжилтийн насны үед бие махбод, сэтгэл зүй, нийгмийн амьдралд гарах өөрчлөлтүүд, эрүүл мэндэд тулгамддаг асуудлууд, ХДХВ/ДОХ болон Бэлгийн замаар дамжих халдварт өвчнүүдийн талаар тодорхой мэдлэгтэй болж, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх арга замын талаар ойлголттой болсон байна.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:
ГБХЗХГ-ЫН ГЭР БҮЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Ч.АНХТУЯА

D:/Бичиг хэрэг /тушаал

169

ГБХЗХГазрын даргын 2021 оны
04 сарын 14-ний өдрийн А/27
дугаар тушаалын 2-р хавсралт

ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨСӨВ

2021 он Говьсүмбэр аймаг

	Бараа материалын нэр	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
Сургалтанд хамрагдаж байгаа иргэдэд нэгж /дата эрх авах/				
1	Мобикомын нэгж	3.000	60	180.000
2	Юнителийн нэгж	3.000	60	180.000
	НИЙТ			**360.000**

Жич:Сургалтыг цаг үеийн байдлаас хамааран цахимаар зохион байгуулах болно.

ТӨСӨВ БОЛОВСРУУЛСАН: ГБХЗХГ-ЫН ГЭР БҮЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ч.АНХТУЯА

D:/Бичиг хэрэг /тушаал